

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ, СОЁЛ

**ХЯТАД ДАХЬ 1925 ОНЫ 5-Р САРЫН 30-НЫ
ХУВЬСГАЛТ ХӨДӨЛГӨӨН****Ч. Далай**

1925 оны Хятадын ард түмний хувьсгалт тэмцлээс хойш 60 жил өнгөрч байгаа бөгөөд түүнийг Хятадын түүхэнд 1925-1927 оны хувьсгалт хөдөлгөөний эхлэл гэж үздэг юм. ХХ зууны эхээр империалист гүрнүүдийн түрэмгийлэл Хятадад улам хүчтэй болж, гадаадын хөрөнгөтнүүд Хятадын газар нутгийг түрээслэн эзэмших замаар олон тооны үйлдвэр завод байгуулаж байлаа. Тухайлбал Япончууд 1925 он гэхэд Хятадад нэхмэлийн 41 үйлдвэр байгуулж амжсан бөгөөд уул үйлдвэрүүдэд 88000 гаруй хөлсний ажилчин ажиллаж байжээ. Нарийвчлан авч үзвэл 41 үйлдвэрээс Шанхайд 58 мянган ажилчинтай 27 үйлдвэр, Циндаод 22 мянган ажилчинтай 8 үйлдвэр, Манжуурт 8 мянган ажилчинтай 5 үйлдвэр тус тус байсны дээр үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн нь бүх Хятадын нэхмэлийн үйлдвэрийн бүтээгдэхүүнүүд 2/3 хувийг эзэлж байжээ.¹ Үйлдвэрийн эзэд—Япон хөрөнгөтнүүд Хятад ажилчдыг хатуу ширүүнээр хэрцгийлэн дарлаж үлэмж хүнд нөхцөлд өчүүхэн бага цалин хөлстэй ажлуулах явдал зуршил болсон байв. Зарим үед ажлын цагийг 12-14 цаг хүртэл сунган ажиллуулдаг байсан боловч ажлын хөлсийг огтхон ч нэмж байсангүй Ялангуяа насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөрийг ихээр хэрэглэн үйлдвэрийн хүнд нөхцөлд ажиллуулаад оронд нь насанд хүрсэн эрэгтэй ажилчдыг ажлаас олон тоогоор халдаг байв. Энэ бүхэнд нь Хятад ажилчдын дургүйцлийг зүй ёсоор хүргэж, ажил хаяж тэмцэх нөхцөл шалтгааныг бүрдүүлжээ.

Чухам ингэж 1925 оны 2-р сарын 9-ний өдөр Шанхайд байсан Японы 22 үйлдвэрийн ажилчид ажил хаяж, түүнд 40 мянга гаруй ажилчин оролцсон билээ. Энэ ажил хаялт Шанхай хотоор үл барам Хятадад байсан гадаадын империалистүүдийг маш их сандралд оруулсан юм. Ажил хаягчдыг зэвсгийн хүчээр харгислан дарсан хэдүй боловч түүнээс хойш гадаадын ноёрхол, түрэмгийллийг эсэргүүцсэн Хятадын ажилчин анги, олон нийтийн тэмцэл хөдөлгөөн улам хүчтэй өрнөв.

Шанхайн ажил хаялтын нөлөө Хятадын бусад нутагт хоромхон зуур дэлгэрч 4-р сарын 19-ний өдөр Циндао хот дахь Японы үйлдвэрийн ажилчдын том хэмжээний ажил хаялт болжээ. Ажил хаялтад 1800 гаруй ажилчид оролцож, 22 хоног үргэлжилсэн шаргуу тэмцэл хийжээ.² Ажилчдын ажил хаялтанд оюутан залуучууд нэгдэж эхэлсэн байна. Империалист гүрнүүдийн түрээслэсэн эзэмшил газарт

1. Ху Хуа. «Чжунго гэмин ши Чжан-и» («Хятадын хувьсгалын түүхийн лекц») Бээжин, 1979, 129-р тал. Дэн Чжунся, «Краткая история профсоюзного движение в Китае». Москва. 1952. 159-р тал.
2. Хятадын хувьсгалын түүхийн лекц. 130-р тал.

байрласан үйлдвэрийн дэргэд үйлдвэрчний эвлэл байгуулагдаж, ажил хаях тэмцэл зохион байгуулалттай болж эхэлжээ.

1925 оны 3-р сарын 12-нд Сунь Ятсен нас барж, Хятадын ардчилсан хувьсгалд ихээхэн гарз учрав. Энэ үед Зөвлөлтийн хэвлэлд Сунь Ятсен нас барсан нь Хятадын үндэсний хувьсгалд маш том гарз учирсан хэрэг гэж тэмдэглээд, Хятадын ардчилсан хөдөлгөөний талынханд Сунь Ятсений тугийг өндөрт өргөж, империализмын эсрэг тэмцлээ үргэлжлүүлэхийг уриалан бичиж байлаа.³

ХКН-ын IV их хурал 1925 оны 1-р сарын 14—21-нд Шанхайд нууцаар хуралдаж, Хятадын хувьсгалын төлөв байдлыг авч хэлэлцээд, пролетари нар хувьсгалыг удирдах ролийн тухай тодорхойлон заажээ. Тэр үед Хятадын Коммунист Нам нь 1000 шахам гишүүнтэй болоод байсны 100 шахам нь Шанхайд ажиллаж байжээ. Их хуралд Коминтерний төлөөлөгч Г. Н. Войтинский оролцжээ.⁴ Их хурлаас В. И. Лениний нас барсны нэг жилийн ойд зориулан «Хувьсгалт хөдөлгөөнд уриалан дуудах бичиг»-ийг гаргажээ. Тэрхүү «уриалан дуудах бичиг»-т тухайлан «Марксын дараа бидний удирдагч Ленин шиг агуу их хүн хэзээ ч байсангүй ... Тэрээр империализмын дарлалын гинжийг бут цохиж, дорой буурай үндэстэнд эрх чөлөө олох тэмцлийн замыг зааж өгсөн»⁵ гэж дурьдсан байв. 1925 оны эхний хагаст Хятадын ажилчин анги, олон түмний хувьсгалт хөдөлгөөн голдуу Шанхай, Циндао, Фучжоуд өрнөж байжээ.

1925 оны 5-р сарын 1-нд ХКН-ын удирдлагын дор Гуанчжоуд Бүх Хятадын үйлдвэрчний эвлэлийн II их хурал хуралдаж, 165 үйлдвэрчний эвлэл, хороод болон ажилчны 540,000 гаруй байгууллагыг төлөөлсөн 277 төлөөлөгч оролцжээ. Их хурлын үед Гуанчжоу хотын гудамжинд 100 мянган хүн оролцсон сүрт жагсаал болж, «Ажилчин, тариачин, цэргүүд хүчээ нэгтгэхтүн !, «Милитаристууд сөнөтүгэй ! » «Империалистууд сөнөтүгэй ! » гэсэн уриа лоозон цуурайтуулж байлаа.⁶ Их хуралд ХКН-аас баяр хүргэсэн захидал илгээжээ.⁷ ХКН-ын захидалд Хятадын ажилчин ангийн ажил хаях тэмцлийн амжилтыг өндөр үнэлээд, хувьсгалт тэмцэлдээ бүх дэлхийн пролетари, хувьсгалт ард түмний дэмжлэг олж, тэдэнтэй нягт холбоотойгоор олон улсын империализмыг эсэргүүцэн тэмцэх нь зүйтэй гэж тэмдэглэжээ. Тус их хурал нь Хятадын үндэсний хувьсгалт хөдөлгөөний өрнөлтөд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн байна. Хятадын үйлдвэрчний II их хурал ХКН-ын шууд удирдлагын дор нэгдэл нягтралтай ихээхэн амжилттай хуралдсан тухайн үеийн бүх ... Дэн Чжунся дурьдтгал болгон бичжээ.⁸ Их хурлаас Бүх Хятадын үйлдвэрчний эвлэлийн холбоо байгуулж, дүрмийг баталсан байна. Мөн 25 хүний бүрэлдэхүүнтэй Гүйцэтгэх Хороо сонгож, даргаар нь Линь Вэйминь, орлогч даргаар Лю Шаоци, Лю Вэньсун, ерөн-хий нарийн бичгийн даргаар Дэн Чжунся-г тус тус сонгожээ.⁸ Их хуралд Үйлдвэрчний коммунист

3. «Правда». 14. Ш. 1925.

4. ХКН-ын IV их хурлын дэлгэрэнгүй материал. «Сяндао» сэтгүүлийн № 101, 841-847-р тал. № 107, 889-893-р тал. № 114 1061-1062-р талд нийтлэгджээ.

5. «Чжунго гунчань дан у нянь Лайчжи чжэнчжи» (1921-1925) (ХКН-ын 5 жилийн мөрийн хөтөлбөр) Б. М. 1926, 124-125-р тал.

6. А. И. Картунова. «Политика компартии Китая в рабочем вопросе. Накануне революции 1925-1927 годов». Москва. 1983, 135-р тал.

7. Уг захидлыг «Сяндао» сэтгүүлд бүрэн эхээр нь нийтэлжээ. «Сяндао», № 12. 1925. 1027-1028-р тал

8. Дэн Чжунся. Краткая история профсоюзного движения в Китае Москва. 1952. 187-р тал.

9. Новейшая история Китая (1917-1927). Москва, 1984, 207-р тал. Рабочий Китай в борьбе против империализма. Отчет первой профсоюзной делегации СССР в Китае. Москва. 1927.

интернационалын төлөөлөгчид оролцсоноос гадна их хурал Хятадын ажилчин ангид хандаж тусгай тунхаг бичиг гаргажээ.¹⁰ Түүнээс хойш Хятадад үйлдвэрчний эвлэлийн байгууллага өргөжиж, Тяньцзинь, Бээжин, Шанхай, Ухань, Циндао, Далянь, Чанша, Гуанчжоу, Сянган, Аоминь зэрэг хотууд гол төвүүд нь болжээ.

1925 оны 5-р сарын 14-нөөс эхлэн Шанхай дахь Японы нэхмэлийн үйлдвэрт дахин ажил хаялт болов. Ажил хаясан ажилчдыг Японы империалистууд дахин буудаж, 10 гаруй хүнийг алж шархтуулсан байна. Тэр үед коммунист Гу Чжэнхун алагджээ. Үүнд Шанхайн ажилчид, оюутан болон өргөн олны дургүйцэл улам хүчтэй оргилж, ажил хаях хөдөлгөөн дахин өргөжжээ. Мөн сарын 22-нд Шанхайн оюутнуудын эсэргүүцлийн хөдөлгөөн дахин гарав. Энэ мэтээр Хятадын ард түмний хувьсгалт тэмцлийн хүрээ өргөжсөөр 5-р сарын 30-наас империализмыг эсэргүүцсэн Хятадын үндэсний хувьсгал бүх Хятад даяар эхэлсэн байна. 5-р сарын 28-ны өдөр ХКН-ын Төв Хорооны хурал Шанхайд болж, ажилчин ангийн эдийн засгийн тэмцэл нь улс төрийн шинжийг олж, империализмыг эсэргүүцсэн Хятадын ард түмний тэмцэл зохион байгуулалтай болж эхэллээ гэж үзээд 30-ны өдөр империалист гүрнүүдийн түрээслэн эзэмшсэн газарт том хэмжээний эсэргүүцлийн сүрт жагсаал хийхээр шийдвэрлэсэн байна. 30-ны өдрийн үдээс урагш Шанхай хотын сургуулиудын 2000 гаруй оюутнууд империалистуудын түрээслэлийн районд очиж, ухуулга хуудас тарааж, хурал цуглаан хийж, ажилчдын цус урсгасаныг эсэргүүцэж, сүрт жагсаал хийсэн бөгөөд жагсагчид «түрээслэн эзэмшсэн газрыг эргүүлж ав!», «империалистууд сөнөтүгэй!», «Шанхай бол хятадынх» гэх мэт уриа лоозон цууриатуулжээ. Энэ үед Английн империалистууд толгойлон оюутны жагсаалыг хүч хэрэглэн тарааж, 100 гаруй оюутныг барьж шоронд хийжээ. Мөн өдрийн үдээс хойш 3 цагт 10000 гаруй хүн Шанхай хотын Наньжин гудамжинд цугларч, «Барьсан оюутнуудыг сулла!», «Хятадын бүх ард түмэн нэгдэгтүн!» гэсэн уриа лоозон цууриатуулжээ. Гэтэл англичууд жагсагчдын эсрэг зэвсэг хэрэглэж буудсанаас болж 11 хүн алагдаж хэдэн арван хүн шархдаж, олон арван хүн баривчлагджээ. Үүнийг Хятадын түүхэнд «усань цань ань» («5-р сарын 30-ны цуст хэрэг явдал») гэж нэрлэдэг билээ. «Тавдугаар сарын 30-ны цуст хэрэг явдал» Шанхай хотын олон түмний тэмцэл эсэргүүцлийн хүчийг нэмж, империализмын эсрэг хөдөлгөөн газар сайгүй өрнөхийн угтал болжээ. Энэ үед ХКН-ын Төв Хороо онц хуралдаанаараа 5-р сарын 30-ны хэрэг явдлыг яаравчлан авч хэлэлцээд, «Саньба» («гурван төрлийн ажил хаялт») гэдгийг зарлажээ. Энэ нь ажилчдын ажил хаялт, худалдааны ажилтны ажил хаялт, оюутны ажил хаялтыг хэлж байгаа ажээ.

Төв Хорооны хурлаас бүх нийтийн ажил хаялт, империализмыг эсэргүүцсэн олон түмний тэмцлийн нэгдсэн фронтыг удирдан зохион байгуулах «гүйцэтгэх хороо»-г байгуулсан байна.¹¹

ХКН-ын шууд удирдлагын дор 6-р сарын 1-нд Шанхайд ажил хаясан том сүрт жагсаал болов. Империалистууд босогчдын эсрэг цэрэг цагдаагийн хүч хэрэглэж харгислал үйлдэх нь улам их болов. 5-р сарын 30-наас 6-р сарын 10 хүртэл 60 гаруй хүн алагдаж, 80 гаруй хүн шархджээ.¹² Гэвч Хятадын ард түмний хувьсгалт тэмцлийн

10. Тунхаг бичгийн бүрэн эх 1925 оны «Известия»-гийн № 5-д нийтлэгджээ.

11. Ли Лисань. «Чжунго чжигун юньдун шияо» («Очерк истории профсоюзного движения в Китае»). Москва. 1927. 48-р тал.

12. Хятадын хувьсгалын түүхийн лекц. 135-р тал.

эрч хүчийг империалистуудын харгислал өчүүхэн ч мохоон зогсоож чадсангүй. 5-р сарын 30-ны Шанхай хувьсгалт хөдөлгөөний нөлөө бүх Хятад даяар тархав. Умард Хятад дахь хувьсгалт хөдөлгөөнийг Хятадын Коммунист намыг үндэслэгчийн нэг Ли Дачжао удирдаж байлаа. Бээжингийн оюутнууд 6-р сарын 3-д хичээлээ хаяж, империалистуудыг эсэргүүцсэн сүрт жагсаал хийж, түүнд 50 мянган хүн оролцов. 6-р сарын 10-нд Тяньаньмэньгийн талбайд 200000 хүний цуглаан жагсаал болж¹³ уриа лоозон хашгирч байлаа Тухайн үед бослого хөдөлгөөнд Бээжингийн ажилчид маш идэвхтэй оролцсон билээ. Умард Хятадын эдийн засгийн чухал төв Тяньшань, Кайлуан зэрэг хотод өрнөсөн хөдөлгөөнийг коммунист Чжао Шиянь удирдаж байжээ. Мөн Манжуур, Шаньдун болон Өмнөд Хятадын нутаг Цзянсуд хувьсгалт хөдөлгөөн хүчтэй дэргэрлээ. 1925 оны 8-р сарын 22-ноос 9-р сарын 30 хүртэл Шанхай хотод бүх нийтийн ажил хаялт болжээ.¹⁴ Ажил хаялтын эсрэг ипериалист харгис хүчин дахин буудаж аллага үйлдэв. Тэр үед ажил хаях тэмцлийг зохион байгуулж байсан коммунист Лю Хуа алагджээ.

Хятадын 1925 оны хувьсгалын тухай Зөвлөлт Холбоот Улсын Гадаад хэргийн ардын комиссар Г. В. Чичерин 1925 оны 7-р сарын 2-нд нийлүүлсэн өгүүлэлдээ «Манай засгийн газар, манай олон нийт өөрсдийнхөө бүрэн эрх чөлөө, тусгаар тогтнол болон өөртөө төвлөрсөн ардчилсан байгууллага байгуулахын төлөө тэмцэж буй Хятадын ард түмний тэмцлийг бүрэн ойлгож байна»¹⁵ гэж бичиж байв.

Хятадын хувьсгалыг олон улсын ажилчин ангийн тэмцэлтэй эв санааны нэгдэлтэй байлгах зорилтын үүднээс бүх Хятадын үйлдвэрчний эвлэлийн холбоо нь олон улсын байгууллагад хандаж тусламж хүссэн нь олон улс орны ажилчин ангийн дэмжлэгийг олж байв. Тэр үеийн Хятадын хэвлэлд мэдээлсэнээр үзвэл зөвлөлтийн ажилчин анги Хятадын тэмцэж буй ажилчин ангид туслах зорилгоор хувь нийлүүлсэн фонд байгуулж, 400 мянган рубль хуримтлуулжээ. Мөн Хятадын ажилчин ангид нь БНМАУ, Герман, Франц, Англи, Америкийн ажилчин анги, дэвшилт хувьсгалт байгууллагаас сэтгэл санааны ба эд материалын дэмжлэг авч байсныг¹⁶ тэмдэглэлтэй.

БНМАУ-ын засгийн газар, Монголын нийт ард түмэн Хятадын ард түмний хувьсгалыг цаг ямагт дэмжиж, эв санааны нэгдэлтэй байв. МАХН-ын Төв Хорооноос Октябрийн социалист их хувьсгалын 8 жилийн ойд зориулан гаргасан уриандаа: «Дэлхийн империалистүүдийн харгислалын эсрэг тэмцэж буй Хятадын хувьсгалчид баяр хүргэе!», «Хятадын хавьсгал мандтугай!» «Империалистууд Хятадаас савраа тат!»¹⁷ гэх зэргээр бичжээ. Мөн БНМАУ-ын залуучууд, үйлдвэрчний байгууллагаас 1925 оны Шанхайн хэрэг явдлын талаар мэдэгдэл гаргаж, империалистуудийн гарт нь амь үрэгдсэн ажилчид, оюутнууд, коммунистуудын гэр бүлд эд материалын тусламж үзүүлэх тухайгаа илэрхийлж байлаа.¹⁸

Октябрийн социалист их хувьсгалын шууд нөлөөгөөр 1925 оноос өргөн далайцтай эхэлсэн Хятадын ард түмний үндэсний хувьсгалт тэмцэл ээдтээтэй замыг туулсаар 1949 оны Хятадын ардын хувьсгалын

13. Новейшая история Китая (1917—1927). 23-р тал.

14. Глунин В. И., Георгий Войтинский. Видные советские коммунисты-участники Китайской революции. Москва. 1970, 83, 84-р тал.

15. Советско-китайские отношения (1917—1957): Сборник документов. Москва зов в пись 1959. 105-р тал.

16. Юрьев М. Ф. Революция 1925— 1927 гг. в Китае. Москва. 1968, 236—237-р тал.

17. Үнэн. 1925. X. 13. № 55.

18. Үнэн. 1927. № 57.

ялалтанд хүрсэн байна. Харин маоистууд, тухайлан «соёлын хувьсгалын» үед, Хятадын 1925 оны хувьсгалын үнэн байдал, мөн чанар тэр хувьсгалыг гардан удирдсан коммунистуудын үйл ажиллагааг мушгин гуйвуулсан элдэв оролдлого хийж байв. Одоо ч гэсэн Хятадын маоист түүхчид түүхийн үнэн бодит байдлыг завхруулсан оролдлого бас хийж байна. Гэвч Октябрийн хувьсгалын чөлөөт үзэл санааны нөлөөгөөр Ази дахины сэргэлтийн эрин үед өрнөсөн Хятадын түүхэнд балрашгүй ул мөрөө үлдээсэн томоохон үйл явдал болсон билээ.

РЕВОЛЮЦИОННОЕ ДВИЖЕНИЕ 30 МЛЯ 1925 Г.
В КИТАЕ
(Резюме)

«Движение 30 мая 1925 года—массовые антиимпериалистические выступления китайского народа в Шанхае и других крупных городах страны означали началом китайской революции 1925—1927 гг. Са мыми крупными событиями «движения 30 мая» стали всеобщая антиимпериалистическая стачка в Шанхае и 16 месячная забастовка Гонконге и Гуанчжоу. Утром 30 мая 2 тыс. Шанхайских студентов двинулись по направлению к международному сэттльменту, неся и выкрикивая лозунги: «Долой империалистов!», «Шанхай—китайцам!», «Возвращайте сэттльмент!», «Народы всего Китая, объединяйтесь!». Империалисты в начале пытались ответить на движение 30 мая» насилием: расстрелами, арестами, концентрацией войск в Шанхае. Особенно непримиримую позицию в отношении бастующих студентов и рабочих занимала Англия. Но их репрессии только усиливали возмущение китайского народа. Рабочий класс являлся авангардом и главной силой движения в Шанхае, Гонконге, Гуанчжоу и ряде других городов страны. Политическое и организационное руководство самого начала этого движения находилось в руках КПК.

Политика единого фронта, имевшая тогда важнейшее значение для развития революции, была разработана и осуществлялась при большой поддержке Коминтерна. Международный рабочий класс трудящиеся разных стран, особенно рабочий класс и народы Советского Союза, оказывали революционным силам Китая интернациональную помощь в их справедливой борьбе за свободу и независимость Китая. 14 июня 1925 года Всекитайская федерация профсоюзов обратилась к рабочим и профсоюзам всего мира с просьбой об оказании помощи. На этот призыв откликнулись рабочие многих стран. По данным китайской печати, рабочий класс СССР к концу июля того же года внёс в фонд помощи китайским рабочим 400 тыс. Рублей. Чувства китайского пролетариата в связи с интернациональной солидарностью выразила Всекитайская Федерация профсоюзов в письме, адресованном ВЦС РСФСР: «Во время борьбы с жестоким и варварским империализмом вы ободряли и поддерживали нас. Ваша помощь придает нам новые силы».

МНРП и правительство МНР оказывали моральную поддержку и посильную материальную помощь революционному движению в Ки-

тае. В лозунгах ЦК МНРП к 8-й годовщине Великой Октябрьской Социалистической революции говорилось: «Привет революционерам Китая, борющимся против мировых империалистов!», «Да здравствует Китайская революция!», «Руки прочь от Китая!». В июне 1925 г правительство МНР выразило свой гневный протест против зверской расправы английской полиции над китайскими рабочими и студентами в Шанхае. Правительством МНР выделялись определенные денежные средства для оказания помощи семьям погибших коммунистов, рабочих и студентов Китая.